

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

## БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН УЛСЫН ХОРООНД

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 8 дугаар сарын 4-ний өдрийн хуралдааны 45 дугаар тэмдэглэлд:


“XII.8. “Токио 2020” зуны олимпын наадамд амжилттай оролцож медаль хүртсэн тамирчдад олгох мөнгөн шагнал, урамшууллын талаар Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан:

1. “Токио-2020” зуны олимп, паралимпийн наадамд амжилттай оролцож, медаль хүртсэн тамирчдад олгох мөнгөн шагналын асуудлыг холбогдох зохицуулалтын хүрээнд зохих журмын дагуу Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх арга хэмжээ авахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдоржид даалгав.

2. “Токио-2020” зуны олимпын наадамд амжилттай оролцож, медаль хүртсэн тамирчдад орон сууцны дэмжлэг үзүүлэх асуудлыг судалж, холбогдох арга хэмжээ авахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Д.Сумъяабазар нарт даалгав.

3. “Токио-2020” зуны олимп, паралимпийн наадамд оролцох Монгол Улсын баг тамирчдын хувцас хэрэгслийн дизайныг зохион бүтээж, урласан “Мишэл Амазонка” ХХК-д Засгийн газрын нэрийн өмнөөс талархал илэрхийлэх зохион байгуулалтын арга хэмжээ авахыг Соёлын сайд Ч.Номин, Биеийн тамир, спортын улсын хорооны дарга Ц.Шаравжамц нарт даалгав.

4. “Токио-2020” зуны олимпын наадамд амжилттай оролцож, дөрөвдүгээр байр эзэлсэн тамирчид, багийн спортын хувьд анх удаа олимпод оролцсон 3x3 сагсан бөмбөгийн эмэгтэй шигшээ багийн тамирчид, Олимпын наадмыг шүүх болзол хангаж, эх орныхоо нэрийг өндөрт өргөж оролцсон спортын шүүгч нарт Монгол Улсын Ерөнхий сайдын батламж олгож, мөнгөн урамшуулал олгох асуудлаар Ерөнхий сайдын захирамж гаргахаар тогтов.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР